Дэлгэрцогт сумын 2023 оны “Хоршоо Хөгжүүлэх Сан”-гийн Хяналтын зөвлөлийн ажлын тайлан

ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ, СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ-ЫН” дагуу зээлдэгч нарын үйл ажиллагааны хэрэгжилт, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор хяналт шалгалт хийлээ.

- Хяналт шалгалт явууласан ажлын бүрэлдэхүүнд

1. Хяналтийн зөвлөлийн гишүүн Ч.Баярмаа
2. ХЗ-ийн гишүүн Ж.Наранцэцэг
3. ХЗ-ийн нарийн бичиг ЖДҮ хариуцсан мэргэжилтэн Б.Сармандах
4. ЗДТГ-ын дарга С.Нарантунгалаг
5. ХХСангийн нягтлан бодогч Г.Дэжидсүрэн

- Хяналт шалгалт хийсэн огноо. 2023 оны 11 сарын 24-27- ний өдрүүдэд

2023 онд “Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэрэгжилтийг дараах иргэдийг шалгалаа.

Үүнд : иргэн А.Нямцэрэн “Оёдол эсгүүр” 30,0 сая,

З.Түвшинтөр, “Махны үйлдвэр болон дайвар бүтээгдэхүүн үйлвэрлэх”-40 сая төгрөг, В.Амаржаргал “авто засвар, гагнуур, төмөр үйлдвэрлэл” 20 сая, иргэн

Д.Мөнхжаргал “Сүү, Сүүн бүтээгдэхүүн” 26,200,000,

П.Амгаланбаатар “ Цагаан идээ үйлдвэрлэл, борлуулалт” -ын чиглэлээр 10,000,000, А.Адъяа “гагнуур төмөр эдлэл” 15,000,000 төгрөгийг тус тус зээлийн хэрэгжилтийг шалгахад :

1. П.Амгаланбаатар “ Цагаан идээ үйлдвэрлэл, борлуулалт” -ын чиглэлээр зээл авсан сүүний чиглэлийн 3 тугалтай үнээ, хашааны хамт худалдан авсан.Энэ зун цаг зуншлага сайхан байсан болохоор хөдөө ойрхон гарч үнээгээ саасан. Сүү, тараг, ааруул, ээзгий, өрөм, зэрэг олон төрлийн сүү цагаан идээ боловсруулан сум аймгийн үзэсгэлэн худадлаанд борлуулан төсөл авсанаас хойш .. төгрөгийн орлого олсон үүнээс ... төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн. 1 иргэнийг ажлын байраар ханган ажиллаж байна. Цаашид өвлийн цагаар сүүний гарц багасдаг учир тараг сүүний борлуулалт хийнэ.

Дүгнэлт: Зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа зээлийн гэрээгээ хангалттай хэрэгжүүлсэн гэж үзэж байна.

2. А.Нямцэрэн “Оёдол эсгүүр-ийн чиглэлээр зээл авсан. ЖДҮ-ын байранд өрөө түрээслэн оёдолоо хийдэг. Шинээр ... тоног төхөөрөмж нэмж авсан. Наадам, цагаан сарын үеэр захиалга ихтэй байдаг бусад үед жижиг оёдолууд хийдэг.

Түр ажлын байраар 2 иргэний тухайн цаг үедээ дуудан ажлуулдаг. Зээл авсанаас хойш ... төгрөгийн орлого олсон үүнээс ... төгрөгийн эргэн төлөлтийг хийсэн.

Дүгнэлт: Зээлийг зориулалтын дагуу ашиглаж байгаа, зээлийн гэрээний дагуу эргэн төлөлтийг хугацаанд төлж байгаа гэж дүгнэсэн.

3. В.Амаржаргал "авто засвар, гагнуур, төмөр үйлдвэрлэл -ийн чиглэлээр зээл авсан Төслийг зориулалтын

Дүнэлт:

4. З.Түвшинтөр, "Махны үйлдвэр болон дайвар бүтээгдэхүүн үйлвэрлэх" чиглэлээр зээл авсан мал нядалгааны байгууламжаа түшиглэн мах нимгэн зүсэгч, махны хөрөө, вакумдагч зэргийг ашиглан нутгийн махныг хэрчиж хөрөөдөн вакумжуулан савлаж өөрийн дэлгүүрээр худалдан борлуулахаар үйлдвэрээ дөнгөж эхлүүлэн ажиллаж байна. Түр ажлын байраар ажилгүй 6 иргэнийг, үндсэн ажлын байраар 2 хүн ханган ажиллаж байна.

Дүгнэлт: төсөлийн хэрэгжилт дөнгөж эхлэж байна гэж дүгнэсэн.

5. Д.Мөнхжаргал "Сүү, Сүүн бүтээгдэхүүн" чиглэлээр зээл авсан. Сүү сүүн бүтээгдэхүүн болох ааруул, тараг, сүү, өрөм, цэлцэгнүүр, хайлмаг, бяслаг, өрөмний рулет, өрөм боорцогны багц зэрэг нэр төрлөөр үйлдвэрлэл явуулж байна. Зээл авсанаар 9 төрлийн тоног төхөөрөмж худалдан авсан үйлдвэрлэлдээ ашиглаж байна. Мөн ажилгүй нэг иргэнийг ажлын байраар хангаж ажиллаж байна. Одоогоор сүүгээ орон нутгаасаа авч чадахгүй байгаа учир Төв аймгаас авч байгаа сүүний үнэ хүйтэрч байгаа учир нэмэгдэж байна гэв. Аймгийн төвд Хуучин МСҮТ-ын байранд үйл ажиллагаагаа явуулж байна. Зээл авсанаас хойш 10 сая төгрөгийн орлого олсон.

Дүгнэлт: Төслийг амжилтай хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн.Зээлийн эргэн төлөлтийн хувьд төсөлөө бүрэн авч чадаагүй учир эхний нэг жилдээ зээлийн хүүгээ төлөөд үндсэн зээлийн төлөлтөө дараа жилээс хийх саналыг мэргэжилтэнд өгсөн түүнийг шийдэж өгөх талаар асууж өгнө үү тэр шийдвэр гархаар төлөлтөө цаг тухай бүрд хийнэ гэж байв.

6. А.Адъяа "гагнуур төмөр эдлэл" Тус иргэн сумын төвд гагнуур төмөр эдлэл хийдэг. Шинээр 7 төрлийн багаж хэрэгсэл болон бусад дагалдах хэрэгсэлийг худалдан авсан.Малын хашаа, хашааны хаалга зэрэг олон нэр төрлийн гаганиуур хийдэг. Одоогийн байдлаар 10 сая төгрөгийн орлого олсон. Хөдөөний иргэд ажлын хөлсөндөө ихэвчлэн мал өгдөг бэлэн мөнгөөр төлбөр хийдгүй мөн сумын хүмүүс зээлээр юм хийлгэдэг учих мөнгөө цувуулж өгдөг болхоор энхий хэдэн сар зээлийн эргэн төлөлтөө хийж чадаагүй гэж байлаа.

Дүгнэлт: төслийг зориулалтын дагуу амжилтай хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн

Одоогийн байдлаар 2023 онд Төсөл хэрэгжүүлэхээр зээл авсан 6 иргэний явуулж байгаа үйл ажиллагаатай танилцлаа. Төсөл хэрэгжүүлэгчдээс: - Зээлийг зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа - иргэн , зээлийн гэрээний хэрэгжилтийг хангалтгүй буюу хугацаа иргэний үйл ажиллагаанд хяналт тавьж "ХХС-ийн шинэчилсэн журмыг танилцуулж мэдээлэл өгч ажиллаа.

- Цаашид
- Зээлийн гэрээнд төслөөр авах тоног төхөөрөмжд хяналт хийх хугацааг тусгах.
- Ажил хүлээлцэхэд зээлдэгч нарын бичиг баримтыг жагсаалтаар хүлээлцэж байх

Иргэдийн үйл ажиллагааны зурган тайлан

1.Д.Мөнхжаргал
.








2.А.Адъяа







3.П.Амгаланбаатар





4. З.Түвшинтөр








5. А.Нямцэрэн












6. В.Амаржаргал